Golomt Capital®

ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт
Нүүрс
Төмрийн хүдэр
Зэс
Газрын тос

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.04.04

Golomt Capital®

АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал: ***2022 оны 4-р сарын 4***

Өнгөрсөн 7 хоногт алтны ханш 1,958.02 ам.долларт нээгдсэн ч 1,925.00 ам.долларт хүрч буурлаа. Ханш өнгөрсөн долоо хоногийн эхний 2 хоногт 3.5 хувийн уналт үзүүлсэн нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг татав.

Үүнд ОХУ болон Украйны талууд энхийн хэлэлцээрийн ширээний ард суух мэдээлэл зарлагдсан нь нөлөөлсөн байна.

Мөн АНУ-д өнгөрсөн сард шинээр бий болсон ажлын байрны тоо сайн үзүүлэлттэй гарсан нь бодлогын хүүг дахин чангаруулах орон зай байгааг илтгэж байна. Энэ нь алтны ханш дахин буурах гол шалтгааны нэг болох юм.

Энэ 7 хоногийн лхагва гаригт Холбооны Нөөцийн Санг хурлын тайлангаа зарлана. Цаашид алтны ханшид дайны нөлөө болон АНУ-ын төв банкнаас хэрэгжүүлж байгаа мөнгөний хатуу бодлого хүчтэй нөлөөлөх юм. Бид алтны ханшийг энэ 7 хоногт уналтаа хадгална гэсэн таамаглалыг дэвшүүлж байна.

Техник шинжилгээ

Алтны хувьд бүх цагийн үеийн түүхэн дээд ханшаа шинэчлэн тогтооход тун ойртсон ч чадсангүй. 1,917 ам.доллар орчимд байрлах дэмжлэгийн цэгийг хүчтэй том лаагаар сэтлэн гарч өдрийн хаалтаа 1,917 ам.доллараар хийж чадвал чиг хандлага доош үргэлжилж ханш 1,860 ам.доллар хүрэх боломжтой.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*

Golomt Capital®

ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал ***2022 оны 4-р сарын 4***

Өнгөрсөн 7 хоногт “West Texas Intermediate (WTI)” газрын тосны ханш нэг баррель нь 112.64 ам.доллараас эхэлсэн ч 99.36 ам.доллар дээр хаагдсан байна. Brent газрын тосны ханшийн нэг баррель нь 118.84 ам.доллараас эцэстээ 105.59 ам.доллар дээр хаагдлаа. Дээрх 2 газрын тосны ханш хоёул нээлтийн цэгээсээ дээш гарч чадалгүй шууд унасан байна.

Ханшийн хөдөлгөөнд дараах хүчин зүйлс нөлөөлөв

АНУ-ын ерөнхийлөгч Жой Байден урьд хожид байгаагүй буюу өдөрт 1 сая баррел газрын тосыг 5 сараас эхлэн 6 сарын турш нийлүүлэхээ мэдэгдсэн. Ингэснээр газрын тосны ханш 13 хувиар унаж сүүлийн 2 жилийн хугацаан дахь хамгийн өндөр уналтыг үзүүлсэн.

Хэрэв геополитикын асуудал үргэлжлэн хурцдах юм бол энэхүү арга хэмжээ үр дүнгүй болж газрын тосны ханш дахин өснө гэж шинжээчид үзэж байна.

Арабын Нэгдсэн Эмират улс болон Ирантай эвссэн Хоути бүлэглэл Саудын Араб-Йемений хил дээрх цэргийн ажиллагааг зогсоох эвлэрлийг нааштайгаар хүлээн авсны дараа нефтийн ханш Азийн зах зээлийн эхэн үед буурч, нийлүүлэлттэй холбоотой сөрөг хүлээлтийг багасгалаа.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*